

**ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ДАЛАЙН ХӨДӨЛМӨРИЙН
ТУХАЙ 2006 ОНЫ КОНВЕНЦИД 2016, 2018 ОНД ОРУУЛСАН НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ
ЗӨВШИЛЦӨХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ
ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 12 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
ХОТ

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцид 2016, 2018 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1-д заасныг үндэслэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд өнөөдрийн байдлаар Монгол Улсын далбаатай хэдэн онгоц, хэдэн далайчин байгаа талаар болон конвенцод нэгдэн орсон гишүүн орон бүр далайчны хөдөлмөрийн гэрээг түүний хүчинтэй хугацаа дууссаныг харгалзахгүйгээр ямар нэгэн халдлагад өртсөн тохиолдолд хүчинтэй хэвээр байлгахыг шаардана гэж заасан байгаа тул энэ хариуцлагыг хэн хүлээх талаар, манай улсын далбаа бүхий хөлөг онгоц далайн дээрэмчдийн халдлага, хүчирхийлэлд өртөж байсан эсэх, холбогдох эрх зүйн зохицуулалт, хариуцлагын талаар ажлын хэсгээс асуусан болно.

Мөн тэрээр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Тяньжинь хотод байгаа манай улсын мэдлийн 10 га газрыг боомтын зориулалтаар ашиглах асуудал удаашралтай явж ирсэн тул энэ талаар ямар бодлого баримталж байгааг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогтоос тодруулан асуугаад, цаашид энэ газрыг үр дүнтэй ашиглах асуудлыг судалж шийдвэрлэх нь зүйтэй талаар үг хэлсэн.

Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан Монгол Улсын далбаатай, бүртгэлтэй хөлөг онгоцны ямар асуудлыг манай улс хариуцдаг, хэрхэн хяналт тавьдаг тухай болон улсын төсөвт төвлөрүүлдэг нийт ашиг, Далайн захиргааны байгууллагын жилийн төсөв, бүтэц, орон тооны талаар асуулт асууж, хариулт авсан.

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцид 2016, 2018 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг эцэслэн батлуулах нь зүйтэй гэсэн саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцид 2016, 2018 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийн зөвшилцөх, хэлэлцүүлэх тухай асуудлыг хэлэлцсэн талаарх

Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД
БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Б.ЭНХ-АМГАЛАН

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Төрийн ордон, Улаанбаатар
хот

**ОЛОН УЛСЫН ХӨДӨЛМӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ДАЛАЙН ХӨДӨЛМӨРИЙН
ТУХАЙ 2006 ОНЫ КОНВЕНЦИД 2016, 2018 ОНД ОРУУЛСАН КОНВЕНЦЫН
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Олон улсын хөдөлмөрийн байгууллагын Далайн хөдөлмөрийн тухай 2006 оны конвенцид конвенцод 2016, 2018 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

Гарын үсэг